

# ЯНГИР ЯМАА

## Siberian Ibex



*Capra sibirica*  
Pallas, 1776

Ангилал зүй /Taxonomy

Хүрээ: Хөвчтөн / Phylum: Chordata

Анги: Хөвчтөн / Class: Mammalia

Баг: Туруутан / Салаа туруутан  
Order: Cetartiodactyla

Овог: Тугалмайтан / Family: Bovidae

Төрөл: Ямаа / Genus: Capra

**Таних шинж:** Хүнд лагс биетэй, хөл богино, сахал урт, эвэр хүнд. Биеийн урт 130-165 см, сэрвээгээрээ 70-110 см, сүүлний урт 10-18 см, чихний урт 14-16

**Characteristics:** Large body, short legs, long beards and with heavy horns. Body length 130-165 cm, shoulder height 70-110 cm, tail length 10-18 cm, ear length 14-16 cm. Weight male 45-153 kg and female 29-90 kg. Condyle-basal length male 26-31 cm and female 23-26 cm. Body coloration of young individuals red, black brown and old ages lighter.

см. Тэх 74-139 см, ямаа 16-38 см урт эвэртэй. Тэхийн биеийн жин 45-153 кг, ямааных 29-90 кг. Тэхийн толгойн ясны (кондилобазаль) урт 26-31 см, ямааных 23-26 см. Залуу бодгаль ихэвчлэн улаавтар, хар хүрэн, хар халтар, хөгшрөх үедээ цайвар халтар зүстэй болно.

**Статус:** Засгийн газрын тогтоол – Ховор амьтан, Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан данс – Устах болзошгүй.

Status: Government resolution - Rare animal. IUCN Red List – Near Threatened (NT).

**Амьдралын онцлог:** Өндөр ууланд 3-40 тоо толгойгоор сүрэглэн амьдарна. Намар, өвөлд олноороо сүрэглэнэ. Зун өглөө оройд, өвөлд өдөржин идээшилнэ. Элдэв зүйлийн өвслөг ургамал иднэ. Идэш тэжээлд үетэн, сонгины төрөл, бут сөөгний навч зонхилно. Ороо хөөцөлдөөнд 11-р сарын сүүлч, 12-р сарын эхээр орно. Хээл тээх хугацаа 140-175 хоног. Ямаа 4-р сарын сүүлчээр нэг, хааяа ихэр ишиг гаргана. Хөхүүл үе нь хагас жил шахам үргэлжилнэ. Бэлгийн боловсролт 2 настайгаас эхэлнэ. Байгалийн нөхцөлд 12-18 жил насална.

**Habits and breeding:** Lives in herds with 3-40 individuals on high mountains. Herds become larger in autumn and winter. Active in the morning and evening, grazes in winter whole day. Feeds on different plant species. Favorite food is onions, leaves of shrubs. Mates in late November and early December. Gestation period 140-175 days. Produces one young, occasionally twins late April. Become sexually mature from age 2 years. Life span 12-18 years.

**Амьдрах орчин:** Өндөр уулсын цавчим хадтай газарт байршин амьдардаг ба улирлаар нутаг сэлгэдэг. ГИДЦГ-ын “Б” хэсгийн Хөвчийн нуруу, Өвөр хад, Тахийн шар нуруу, Тахийн Хөх өндөр, Хавтаг, Байтагийн уулс, Алагхайрхан уулын БНГ янгиртай.

**Habitat:** Rocky canyons of high mountains. Migrates seasonally. Found in Khovchiin nuruu, Ovor khad, Takhi shar nuruu, Takhi huh undur, Khavtag, Baitag mountains of Great Gobi B Strictly Protected Area and Alaghairkhan mountain Nature reserve.